

## МОНГОЛ БОЛОН МОНГОЛЧУУДЫН ТУХАЙ АМЕРИКИЙН АРХИВЫН МАТЕРИАЛ: ТҮҮНИЙ МӨН ЧАНАР, АЧ ХОЛБОГДОЛ, ХЭРЭГЛЭХ БАЙДАЛ

Этвуд Христофер

**Өгүүллийн товч утга:** Энэхүү өгүүлэлд АНУ-ын нийслэл Вашингтон хотын Үндэсний Архивын ордонд хадгалагдаж байгаа монголчуудын тухай Дундад иргэн улс дахь америкийн дипломатын баримт бичиг, материалын аравтын болон сэдэвчилсэн томъёг, тэдгээрийн агуулга, ач холбогдол ба бусад холбогдох түүхийн хэрэг явдлын тухай өгүүлжээ.

**Түлхүүр үг:** Монгол болон монголчууд, америкийн архив, дипломатын баримт бичиг, товъёог, аравтын ба сэдэвчилсэн товъёг, ангилал, агуулга.

1985 он хүртэл америкийн дипломатын материалын түүхийг бичихэд бараг хэрэглэгдэггүй байсан билээ. Гэвч тэр цагаас хойш америкийн нэгдсэн улс хэдийгээр орос, хятад, япон шиг монголын ендөрлөг дээр нутаг дэвсгэр эзэмшиж болох хүчирхэг улс биш боловч дипломат болон худалдааны талаар монголын өндөрлөгт дөрөв дэх хүчтэй орон гэдэг нь илэрхий болсон юм. Иймээс америкийн дипломатууд болон иргэд монголтой холбогдсон харилцааны талаар нэлээд ач холбогдолтой, архивын материал цуглувансан байна. Энэ өгүүлэлд би монгол болон өвөр монголын монголчуудын одоо эрдэм шинжилгээний хэрэгцээнд бэлэн байгаа Төрийн Департаментын материалын танилцуулна. Эндерсон Майэр Компани, Рой Чэпман Эндрюс, Дэд Ерөнхийлөгч Гэнрих Уаллас гэх мэтийн хүмүүсийн хувийн архивт нэмэлт материал хадгалагдаж байж магадгүй боловч одоо чухам хаа байдаг нь надад тодорхой биш байна.

Америк, монголын өвөрмөц харилцаа нь монгол болон монголчуудын талаар америкийн архив дахь байр суурийт тодорхойлдог. 1911 оноос хойш гуч гаруй жил америк улс нь хятадын дундад иргэн улсад итгэмжлэх жуух бичгээ барьсан тэр дипломат шугамаар ар, өвөр монголчуудтай холбоо барьдаг байв. Америкийн дипломатууд монголтой 1922 оноос хойш шууд холбоотой байгаагүй боловч өвөр монголын улс төрийн байгууллагуудтай 1949 он хүртэл холбоотой байсан юм. Хятад улсаар дамжилгүйгээр шууд харилцсан америк, монголын харилцаа нь Дэд Ерөнхийлөгч Гэнрих Уалласын 1944 оны айлчлалаас эхэлсэн билээ. Ю.Цэдэнбал Монгол улсыг НҮБ-д элсүүлэх өргөдөл барихаар Нью Йоркад 1946 онд айлчлал хийснээс эхэлж, 1961 онд Монгол Улс НҮБ-д элсэх асуудлаар дамжаад 1987 онд Монгол улстай дипломат харилцаа тогтоох хүртэл АНУ-ын засгийн газар нь монголыг ЗХУ-ын дагуул орон мэтээр үзэж байв. Ганцхүү 1990-ээд оноос хойш тухайлбал, 1990 оны ардчилсан хувьсгалын ачаар америк, монголын харилцаа жинхэнэ биеэ даасан зарчим дээр бүх талаар хөгжих боллоо.

### АНУ-ЫН Үндэсний Архивын Газар дахь архивын материалыг хэрэглэх нь

АНУ-ын Төрийн Департаментын архив Вашингтон хотын Үндэсний Архивын Ордонд хадгалагдаж байна. Вашингтонд дипломатуудын илгээсэн илтгэлүүдийг эхлээд аравтын товъёог (1910-1963), дараа нь сэдэвчилсэн тоотын товъёог (1963-1973)-т оруулжээ. Аравтын товъёог нь америкийн талаас шаардаж байгаа холбогдох үйл явдлаар хуваагдаж байна. 1950 оноос өмнө дараах ангиллаар хувааж байжээ. Үүнд:

- 1: АНУ-ын засгийн газрын дотоод захиргаа
- 2: Хууль зөрчсөн хүмүүсийг гадаад улсад барьж өгөх
- 3: Улсын болон иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах

хоёрдахь консул Эдвин Ф. Стэнтон 1924 онд томилогдсон боловч монгол улсад хүрэлцэн ирсэнгүй. Хамгийн сүүлчийн консул Луис Кларк 1926 оны 12-р сард томилогдсон бөгөөд тухайн үеийн хятадын иргэний дайны улмаас наймаа худалдаа бараг зогссоны дээр тусгаар монгол улстай харилцаа байгаагүй гэж элчин сайд яамандаа илтгэжээ. Гэхдээ Дамбадоржийн удирдлагын дор германтай няйт харилцаа тогтоо замаар монгол орон дахь зөвлөлт холбоот улсын нөлөөг багасгах оролдлого хийж байсныг ажигласан байна.

Чуулалт Хаалганд консулын газар байгуулахаас өмнө Бээжин дэх америкийн элчин сайдын яам монголын холбогдолтой үйл явдлыг шууд хамаарч байв. Жишээ нь, Жалханз Хутагт 1919 оны 11-р сард америкийн талаас тусламж хүсч, америк улсыг консулын газраа Хүрээнд байгуулахыг уриалсан Богд хааны захиаг яамны ажилтан Тенид дамжуулж өгчээ. (Энэ захианы зөвхөн англи хэлээрх орчуулга байгаа бөгөөд монгол эх нь америкийн архивт хадгалагдаагүй юм.)<sup>1</sup> Бээжин дэх ерөнхий консул Чарлс Эберхарт 1920 оны 4-р сард монголд айлчилж, америкаас тусламж гүйх Богд хааны өөр нэг захиаг хүлээн авсан байна. Энэ захианы монгол эх америкийн архивт англи, хятад орчуулгын хамт хадгалагдаж байна.<sup>2</sup>

Америкийн Архивын Ордонд хадгалагдаж байгаа нийт тавин боть Чуулалт Хаалган (албан ёсоор Ваньцюэн хот гэдэг)-ы консулын газрын бичиг баримтыг Алиша Кэмпи задлан шинжилж америк, монголын харилцааг судалсан билээ.<sup>3</sup> Түүний судалгааны хамгийн сонирхолтой хэсэг бол, консул Сокобины монголд хийсэн дөрвөн удаагийн айлчлал болон Бодоо, Богд хаан, Жалханз Хутагт, тухайн үеийн Сангийн Яамны сайд С.Данзан, түүний зөвлөлтийн зөвлөх Бутин, жанжин Сүхбаатар түүний зөвлөх Хува, Цэрэндорж гэх мэтийн хүмүүстэй уулзсан үйл явдлыг тодорхойлсон зүйл болно. Кэмпигийн зохиолд Сокобиныг Пунцагдорж, Бодоотой хамт монголын засгийн газрыг унагахаар сүлбэлдсэн хэмээн монгол, зөвлөлтийн талаас ялласан нь архивын хувьд огт үндэслэлгүй гэж дүгнэжээ. Консулын газрын архивын мэдээгээр бол, Сокобин 1921 оны наймдугаар сард Ерөнхий сайд Бодоотой албан уулзалт хийсний дараа түүнтэй дахин өрөөсөө уулзаагүй байна. Харин Сокобин 1922 оны хавар дэгдсэн "Үйлльямсын хэрэг" гэгчийн талаар хэдэн тааруухан шийдвэр авчээ гэж Кэмпи цааш нь тодорхойлжээ. Монгол, зөвлөлтийн эрх баригчдын үзсэнээр бол, Сокобин Барон Унгэрн-Штэрнбэргийн нэг алуурчин Кунхарт гэгчийг монголоос зугтахад нь тусалсан гэдэг. Кунхартэд баталгаа гаргаж өгсөн америкийн иргэн Роберт Уйлльямсыг Сокобин эхлээд монгол улсын эрх баригчдаас нуугаад дараа нь Хүрээ орох замд нь Уйлльямсыг барьж монголын хилээр гаргахаар оролджээ. Кэмпигийн үзлээр бол, Сокобин монголын төрийн байдлыг бараг ойлгоогүй, хуйвалдаан гаргах хүрэлцээтэй туршлага чадвар ч үгүй байсан. Гэвч энэ хэрэг дээр монголын засгийн газрын хууль ёсны эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байдал гаргаж, монголын засгийн газрын сэжиг төрүүлсэн байна. Яагаад хүлээн зөвшөөрөхгүй вэ гэвэл, тухай үеийн Хятад дахь гадаад улсын иргэд ганц өөрийн дипломатаар шүүгдэх эрхтэй байжээ. Сокобин энэ онолыг үндэслэж, Уйлльямсыг шүүх эрх монголын засгийн газарт байхгүй, ганцхүү америкийн консулд л байгаа гэсэн байр суурь баримталжээ.

Хаалгын консулуудын илтгэлийн дотор монголын улс төр, эдийн засгийн байдлыг илрүүлсэн чухал мэдээ байдаг юм. Жишээ нь, Сокобины 1921 оны найм, есдүгээр сар, 1922 оны нэгдүгээр сарын айлчлалын тухай хоёр илтгэл нь монголын улс төрийн уур амьсгал Бодоог огцруулсанаас хойш яаж

<sup>1</sup> Alicia Campi, *Political Relationship Between the United States and Outer Mongolia, 1915-1927*, 40-41 дэх талыг үзнэ үү.

<sup>2</sup> Alicia Campi, *Political Relationship Between the United States and Outer Mongolia, 1915-1927*, 50-55 дахь талыг үзнэ үү.

<sup>3</sup> Alicia Campi, *Political Relationship Between the United States and Outer Mongolia, 1915-1927*, (Ph.D.Dissertation, Indiana University, 1987) үзнэ үү.

өөрчлөгдсөнийг тодорхойлдог. Үүний хоёрдахь илтгэлийн дотор бас Хөлөн Буйрын Цэнд гүн хятадын хэдэн алба хаагчдын хамт урьд түүхэнд огт анхарагдаагүй нэгэн айлчлалаар 1922 оны нэгдүгээр сарын 17-ны өдөр Нийслэл Хүрээнд очсоныг бас тэмдэглэсэн юм.<sup>1</sup>

Кэмпигийн судалгаа консулын илтгэлийн хамт монголын засгийн газрын зарим баримт бичгийг хэвлэжээ. Жишээлбэл, 1920 оны 4-р сарын 15-ны өдрийн Богд хааны тусламж хүссэн захия; 2) Монголын Ардын Намын анхдугаар программ (монгол, хятад хэлээр); 3) Монголын ардын засгийг хүлээн зөвшөөрөхийг америкаас хүссэн Бодоо сайдын 1921 оны 9-р сарын 12-ны өдөр бичсэн захия (монгол, хятад хэлээр); 4) Богд хааны 9-р сарын 14-нд бичсэн, монгол жинхэнэ тусгаар улс болсныг хүлээн зөвшөөрөхийг америкаас хүссэн захия (монгол, хятад хэлээр) гэх мэт болно. Нэн сонирхолтой нь, тэр баримтуудын англи хэлний орчуулга олон алдаатай байгаа нь монгол, америк хоёр улсын хооронд харилцаа тогтооход хэлний саадын учир холбогдол байгааг харуулдаг.

Харбин хотын консулын газрын ажилтнууд бас монголын хэрэг явдлыг ажиглан сонирхож байв. 1918 оноос Харбины консулын газрынхан оросын иргэний дайн, японы интервенцийг байцаан судалж байв. Тэндхийн консулынханд монголыг ийм идэвхтэйгээр ажиглан судлах даалгавар байгаагүй ч гэсэн Хөлөн Буйрт дэгдсэн ноцтой хэрэг явдлуудад нэлээд анхаарал тавьжээ. Ноосны худалдаа Хөлөн Буйраас халхын зүүн хэсэгт үргэлжилсэн учраас консул Жорж Хэнсон (1921 оны сүүлчээс 1934 оны эхэн хүртэл ажиллаж байв) болон Сокобин (1925 онд зэрэгцэн консул байв) монголын хэрэг явдлыг Хөлөн Буйртай холбогдуулан тэмдэглэжээ. Гол сурвалж нь оросын цагаан намын худалдаачид, Харбин хотын хятад, цагаан, улаан орос болон япон хэлний сонинууд байв. Харин Хэнсон бас Хайлаарт хэдэн удаа айлчилж Цэнд Гүн, Фумин (хувьсгалын нэр нь Буюнгэрэл) хоёртой сайн танилцжээ.

“Өвөр Монголын эмх журамгүй жилүүдийн Залуу Монгол хөдөлгөөн болон дугуйлангийнхан” гэдэг ном<sup>2</sup> бичихдээ зохиогч миний бие Хаалган, Харбин хоёрын консулын материалыг ашигласан юм. Өвөр монголын материал дөрвөн төрөл болон хуваагдана. Үүнд: 1) консулынхан монгол нутагт айлчлахдаа үзсэн зүйлийн тухай илтгэл; 2) Элчин сайдын яамнаас төрийн департаментэд шилжүүлсэн монгол хэлээрх баримт бичиг; 3) нутгийн хүмүүсээс сурвалжлан авсан мэдээ; 4) нутгийн сонины өгүүлэл. Үүнээс эхний хоёр төрөл нэлээд анхаарал татдаг. Жишээ нь, Харбины консулын газрын албан хаагч Т.Ленард Лилльиенстромын “Хайлаар, Баргын зарим газарт айлчилсан тухай меморандум” онц сонирхолтой юм.<sup>3</sup> Энэ меморандум нь 1925 онд Цэдэн-Иш, Мерсе, Фуминтай, Цэнд гүн тэргүүтэй Хайлаарын харилцан туслалцах хоршоо байгуулсан монополийг америк, англи хоёр орны консулынхан цуцлахаар явсан айлчлалын тухай өгүүлдэг. Үүнээс тухайн үеийн Хөлөн Буйрт хятадын албан хаагчид, Дагуур-Баргын хошууны ноёд эрхийг хослон барих байдал тодорхой харагдаж байна. Энэ баримт бичиг, мөн сэдвийн тухай Хуалинтай, Мерсе, Цэдэн-Иш гурвын өөрсдөө МАХН-ын Төв Хороонд бичсэн захия үүнийг яг батлан нотолдог.<sup>4</sup>

Харамсалтай нь, американ дипломатууд 1924-1925 оны хоорондох өвөр монголын ганц хоёрхон баримт бичгийг цуглувансан юм. Жишээ нь, Консул Хенсоны баримтанд Баргын 1928 оны хувьсгалын тухай уг баримт материал огт олдоогүй. Хаалганы консул Эдвин Стентон гэгч Дотоод Монголын Ардын

<sup>1</sup> Alicia Campi, Political Relationship Between the United States and Outer Mongolia, 1915-1927, 137 дахь талыг үзнэ үү.

<sup>2</sup> Голландын Лейден хотын Е.Ж.Брилл гэдэг хэвлэлийн газраас 2002 онд хэвлэв.

<sup>3</sup> Atwood, Young Mongol and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931, 1 дүгээр боть, 426- 432 дахь хуудас

<sup>4</sup> МАХН-ын төв архив, 7-1-29:28 хуудсыг үзнэ үү.

Хувьсгалт Намаас 1925 оны 12-р сарын 20-ны өдрийн тунхагийг Элчин Сайдын Яаманд явуулсан юм. Харин хамт хавсаргасан англи орчуулга нь маш буруу бөгөөд хүний нэрийг танигдашгүй буруу галигласан байв.<sup>1</sup>

Стентон, Хенсон нараа тайлан нэг их гүнзгий ойлголт төрүүлдэггүй ч гэсэн Фэн Юй Сян, Жан Цзо Линь гэх мэтийн цэргийн эрхтний нааш цааш дайлсан тухай олон найдвартай мэдээлэл агуулжээ. Жишээ нь, Консул Стентон өөрөө Хаалган хотод 1925 оны 10-р сарын 13-нд болсон Дотоод Монголын Ардын Хувьсгалт намын анхдуугаар их хурлын тухай юу ч сонсоогүй. 1928 оны баргын хөдөлгөөний тухай Консул Хенсоны зарим мэдээ үнэн магадлалтай бус, шуугиан тарих мэдээлэгчдээс авсан байdag билээ. Нэн ашигтай сурвалж нь орос, хятад, япон сонины өгүүллүүд юм. Харин энэ өгүүллүүд архивын дотор зөвхөн англи орчуулгаар байdag бөгөөд орчуулга нь зарим нэг алдаатай байж магадгүй байна.

АНУ-ын цэргийн атташе 1919 оноос 1921 он хүртэл халх монголд гарсан хэрэг явдлуудыг нэлээд сонирхож байв. Хурандаа Филун, Мэгрюдер хоёр туслагч цэргийн атташе монголд 1920 оны 10, 11 дүгээр сард американын худалдаачдыг аюултай байдлаас хамгаалахаар дараалан айлчилж бүрэн тайлан бичжээ. Энэ зууны эхний хагасын АНУ-ын цэргийн тагнуулын тайлантууд АНУ-ын цэргийн тагнуулын тайлан: *Хятад, 1911-1941 он гэдэг нэрээр 15 дамар бүхий бичил хальс зурагтайгаар 1983 онд хэвлэгджээ.*<sup>2</sup> Никола ди Космо нэг өгүүлэл бичиж энэ бичил хальс зургийн дотор байгаа монголын тухай мэдээг товчлон танилцуулав.<sup>3</sup> 1920 оны дунд болон сүүл үеэс цэргийн тагнуулын тайланд монголын тухай сэдэв гардаг, гэхдээ энэ нь найдвартай бус, цуурхал ихтэй, жинхэнэ мэдээлэл ховор байна.

Төрийн Департаментын 893 тоот аравтын товъёг 1985 оны *Хятадын Дотоод Хэргийн тухай АНУ-ын Төрийн Департамент Баримт Бичгүүд* гэгч бичил зургийн цуврал болгож АНУ-ын эрдэм шинжилгээний олон номын санд хадгалуулав. Үүнд, Хаалган, Харбин, цэргийн тагнуул гэх мэтийн материал сэдэв, он сар өдрөөр ангилагдаж байна. Энэ баримтууд дөрвөн цуврал болон хэвлэгджээ. Үүнд:

- 1) 1940-1944, 43 дамар;
- 2) 1945-1949: 69 дамар;
- 3) 1910-1929: 227 дамар;
- 4) 1930-1939: 167 дамар;

Би американын архивын материалыг энэ хэлбэрээр нь хэрэглэсэн юм. Дэ Вангийн хөдөлгөөнийг судлахад их хэрэгцээтэй материалтай аж. Даанч энэ цувралд тусгаар монгол улсын холбогдолтой материал багтаагүй байна.

Америкийн монгол өндөрлөгийн худалдаа 1925 оноос хойш доройтох, Хаалганы консулын газар 1927 оны 9-р сарын 30-нд хаагдас. Харбины консулын газар 1941 оны сүүлч хүртэл ажиллаж байсан боловч монголын хэрэг явдлыг сонирхдог Жорж Хенсоныг 1934 оны эхээр шилжүүлсэн билээ. *Хятадын Дотоод Хэргийн тухай Баримт Бичгүүд* гэдэг бичил зургуудад Дэ Вангийн автономит хөдөлгөөний тухай олон хэрэгцээтэй материал байж болмоор, гэвч одоо хүртэл эрдэмтдэд хэрэглэгдээгүй байна. Тэрчлэн дэлхийн хоёрдугаар дайны дараа америк монголчуудыг сонирхож нь 1922 оноос хойш урьд үзэгдээгүй хэмжээнд хүрч, дипломатууд болон хувийн ажиглагчид өвөр монголд гэнэт гарсан нармай Монгол, тусгаар тогтнол, автономит олон хөдөлгөөний тухай элбэг материал цуглуулав. Харин өвөр монголын ихэнх нутаг дэвсгэр

<sup>1</sup> Atwood, *Young Mongol and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931*, 1 дүгээр боть, 3-6 дахь хуудас. 2 дугаар боть, 517-518 дахь хуудсыг үзнэ үү. Мөн энэ нь Намын төвийн архивын 7-1-26: 63 дахь хуудсанд байна.

<sup>2</sup> Frederick, Maryland: University Publications of America, Inc., 1983.

<sup>3</sup> Nicola Di Cosmo, "Mongolian Topics in the U.S.Military Intelligence Reports", *Mongolian Studies* 10 (1986-87), 97-106 дахь хуудсыг үзнэ үү.

эхлээд БНМАУ, ЗХУ-ын тал, дараа нь Хятадын Коммунист Намын талыг баримталдаг хүчнүүдийн харьят болсон учраас АНУ-ын дипломатуудад биечлэн нөхцөл байдлыг үзэх завшаан бараг байгаагүй юм. Энэ цаг үеийн Хятадын Дотоод Хэргийн тухай Баримт Бичгүүдийг бас одоо хүртэл эрдэмтэд хэрэглээгүй байна.

1947-1948 онд Төрийн Департаментын тагнуулын мэдээ цуглуулан тархаах газар хоёр нууц баримт бичиг бэлтгэв. Нэг нь дайны дараах Өвөр монголын улс төрийн хэрэг явдлууд (бичсэн он сар өдрийг би мэдэхгүй), хоёрдахь нь өвөр монголын онц чухал монголчуудын намтар (1948 оны 1-р сарын 14-ны өдөр бичив). Хоёрдахь тайлан (би нэгдэхийг нь биечлэн үзээгүй) голдуу Тагнуулын Төв Газрын тайлангууд болон хятадын зарим сониньг үндэслэн эмхэтгэв. Агуулга нь онц чухал хүмүүсийн намтрын гол үйл явдлууд, түүний улс төрийн бодлого, нэн ялангуяа, Гоминдан, Коммунист нам хэрхэн үздэг зэрэг болно. 1972 онд Вашингтон хот дахь Эрдэм Шинжилгээний номын сангийн холбооны хятадын эрдэм шинжилгээний Материалын төв шинээр ил болсон АНУ-ын тагнуулын 1946-1949 оны баримт бичгүүдийг нэг ном болгон эмхэтгэв.<sup>1</sup> Энэ номын материалуудын уг чанар нь дээрх хоёр тайлантай адилавтар, гэхдээ яг адил биш байна.

Америкийн дипломат тагнуул өвөр монголын тухай заримдаа тодорхой мэдээ олж чадаагүй учраас энэ эмхтгэлүүдийн материалын үнэн магадлалт чанар нь жигд бус юм. Тодорхой нэгэн улс төрийн үзэл баримтлааас гарсан нь бас мэдээж. Харин хятадад ная, ерээд оны үед хэвлэгдсэн "Соёл түүхийн материал" хэмээх цуврал бичиг гэх мэтийн өөр байдлаас бичсэн материалыг харгалzan үзэж хянамгай хэрэглэвэл маш үнэ цэнэтэй мэдээлэл өгч чадна.

#### АНУ-аас БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөх тухай

##### асуудал америкийн архивт

1944-өөс 1987 он хүртэл монгол-америкийн хоорондох шууд харилцаа нь голдуу албан ёсны харилцаа тогтоох асуудал төдий л байсан билээ. Энэ цаг үеийн монгол руу хандсан америкийн үзэл, дипломатын алхамуудыг судлах гол сурвалж нь Америкийн Гадаад Харилцаа гэгч асар том баримт бичгийн түүвэр юм. 1861 оноос эхэлж 1969 он хүртэл одоогоор 350 гаруй боть хэвлэгджээ. Энэ цуврал бичгийг ерөнхийлөгчдийн архив, Төрийн болон Батлан Хамгаалах Департамент, Улсын Аюулгүйн Зөвлөл, Тагнуулын Төв Газар, Олон Улсын Хөгжлийн агентлаг гэх мэтийн албан, хувийн баримт бичгүүдээс сонгосон юм. 1945 оноос хойших зарим ботийг вэб хуудсаар үнэгүй хэрэглэж болно.

Эрдэмтэд одоо хүртэл энэ материалыг ашиглаж америкийн "Хүйтэн дайны" үеийн монголын бодлогыг судлаагүй юм. Зарим сэдэвт, жишээлбэл Дэд Ерөнхийлөгч Генрих Уалласын монголд хийсэн айлчлал болон Ялтын бага хурлын тухай материал нэлээн ховор байна.<sup>2</sup> Харин америкийн судлаачид Номхон далайн дайн дуусахаас өмнөх монголын хэрэг явдалд анхаарал тавиагүй шалтгаанаас болсон бололтой. Харин Америкийн Гадаад Харилцааны 1945 оны 7-р боть дахь дайн дууссаны дараахь монголын тухай мэдээ нь монгол, өвөр монгол руу хандсан америкийн бодлогыг тодорхой харуулдаг.

Монголын талаар Америкийн Гадаад Харилцааны хамгийн сонирхолтой шинэ материал бол БНМАУ НҮБ-д элсэх, АНУ-ын Ерөнхийлөгч Кенеди БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхийг оролдсон тухай зүйл байна. Америкийн Гадаад Харилцааны Кенедийн засгийн газрын 22-р ботийн "Хятад", "Монгол" гэсэн бүлэгт дараахь сонирхолтой баримт байна.<sup>3</sup>

<sup>1</sup> *Documents on Inner Mongolia: Selected U.S. Intelligence Reports (Declassified) on Leaders and Factions in Inner Mongolia, 1946-1949* (Washington: Center for Chinese Research Materials, 1972).

<sup>2</sup> *Foreign Relations of the United States: Diplomatic Papers*, vol YI, China (Washington: United States Government Printing Office, 1967), 243 дэх хуудсыг үзэх үү.

<sup>3</sup> [http://www.state.gov/www/about\\_state/history/frusXXII/index.html](http://www.state.gov/www/about_state/history/frusXXII/index.html) гэгч вэб хуудас үзэх үү.

32-р зүйл: АНУ-ын Төрийн Департаментын нарийн бичгийн дарга Дин Раск, тайван дахь Дундад Иргэн Улсын ерөнхийлөгч Цзян Кай-ши хоёрын монголын асуудлын тухай хэлэлцээрийн протокол (1961 оны 6-р сарын 21)

42-р зүйл: Ерөнхийлөгч Кенедигээс ерөнхийлөгч Цзянд явуулсан Монголын холбоотой захиа (1961 оны 7-р сарын 14)

44-р зүйл: БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхтэй холбогдсон Америкийн Цагаан Ордны бага хурлын протокол (1961 оны 7-р сарын 28)

46-р зүйл: Ерөнхийлөгч Кенеди ДИУ-ын дэд ерөнхийлөгч Чень Чен нарын хийсэн монгол руу хандах хятадын бодлогын тухай хэлэлцээр.

192-р зүйл: Төрийн Департаментын нарийн бичгийн дэд дарга Хильсманаас Төрийн Департаментын нарийн бичгийн дарга Раскт бичсэн меморандум (1963 оны 10-р сарын 22.)

198-р зүйл: Дин Раскаас Ерөнхийлөгч Кенедид бичсэн меморандум. (1961 оны 5-р сарын 23)

199-р зүйл: Төрийн Департаментээс Москва дахь Элчин сайдын яаманд явуулсан цахилгаан (1961 оны 5-р сарын 29).

Энэ баримтууд бүр Төрийн Департаментын вэб хуудсан дээр үнэгүй тавигдсан байна. Монголын тухай ховор зүйлүүд өөр ботид бас тохиолдож байна. Энэ цуврал ганцхан хамгийн сонирхолтой материал цуглуулдаг учраас судлаачид энэ сэдвийг гүнзгий судлахад Төрийн Департаментын архив, Ерөнхийлөгч Кенедигийн дурсгалын номын сан гэх мэтийн газраас өөр баримтыг заавал хайх хэрэгтэй. Гэхдээ энэ материалыг голдуу америкийн төрийн бодлогын үүднээс бичсэн учраас монголын дотоод байдлын тухай тийм ч элбэг мэдээ байхгүй байна.

1987 оноос хойших америкийн дипломатын архив нь мэдээж элбэг материалтай боловч Мэдээллийн Эрх Чөлөө Хуулийн зохих шаардлагын дагуу нэг тусгай өргөдөл өгөөд л баримт олж авах нь тийм ч баталгаатай биш байна.

#### Дүгнэлт

Дээр дурдсан материал нь Үндэсний Архивын Ордонд байгаа архивын материалын бүрэн бус түүвэр болно. Олон нийтэд ил, хүртээмжтэй материалыг эрдэмтэд одоо болтол бүрэн ашиглаж эхлээгүй байна. Иймээс ирээдүйд америкийн архив дахь монголын тухай баримт хэрэглэгдэхүүнийг уншиж ашиглах нь дэлхийн монгол судлалд нэн чухал хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

**Abstract:** This article is about the American Archival Resources on Mongolia and the Mongol: Their Nature, Utility, and Availability. The documents surveyed above are undoubtedly are only part of the State Department material that has now been declassified and would presumably be available at the National Archives Building. As I have noted scholars have only begun to use even the widely available American archival materials on Mongolia. I look forward to seeing their use contribute to the further development of world Mongolian studies.

#### Ном зүй

1. Alicia Campi, Political Relationship Between the United States and Outer Mongolia, 1915-1927
2. Frederick, Maryland: University Publications of America, Inc., 1983.
3. Nicola Di Cosmo, "Mongolian Topics in the U.S. Military Intelligence Reports", Mongolian Studies 10 (1986-1987)
4. Atwood, Young Mongol and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931. Leiden. 2002
5. MAXH-ын төв архив

6. Documents on Inner Mongolia: Selected U.S. Intelligence Reports  
(Declassified) on Leaders and Factions in Inner Mongolia, 1946-1949  
(Washington: Center for Chinese Research Materials, 1972)
7. Foreign Relations of the United States: Diplomatic Papers, vol YI, China  
(Washington: United States Government Printing Office, 1967)